Тэтгэврийн даатгалын нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг хуульд заасан хугацаанд багтаан баталж байх, мөнгөжүүлсэн орлогыг хөрөнгө оруулалтын байдлаар ашиглах сонголтын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;	1	1	1	0	-	100	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар 27.7 дахь хэсэгт "Энэ хуулийн 27 6-д заасан тухайн жилийн хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтийг харгалзан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно" гэж заасны дагуу тус газраас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Үндэсний статистикийн хорооноос санал авч Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн хуралданаар хэлэлцүүлж батлуулав. Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мэдээллийн технологийн төвд даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны үлдэгдэл буюу 2024 оны эхний үлдэгдэл болон 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод 11.34 хувиар тус тус хүү тооцон, 2024 оны нэрийн дансны орлогын эцсийн үлдэгдлийг тодорхойлж, цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, "Нийгмийн даатгал" аппликейшн болон portal.ndaagal.mn цахим хуудсаар дамжуулан даатгуулагчдад мэдээлэл хүргэх ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025.09.12-ны өдрийн "Шийдвэр хүргүүлэх тухай" 04/2191 дугаар албан бичиг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна" гэж заасан. Нийгмийн даатгалын ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэтгэврийн нөөц санд 2024 онд 212.2 тэрбум төгрөг, 2025 онд 25.0 тэрбум төгрөг, нийт 237.2 тэрбум төгрөгийг банкны системд нөлөө бүхий ХААН, Худалдаа хөгжил, Голомт, Төрийн банканд төвлөрүүлээд байна. Мөн хуулийн 29.5-д тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны Банканд байршуулах мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулахаар тус тус заасан. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлж, даатгуулагчаас санал авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тухайлбал Монгол банкнд хандаж 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр "Мэдээлэл хүсэх тухай" 01/2030 дугаар албан бичгээр банкны системд нөлөө бүхий арилжааны банкны мэдээлэл, 01/2049 албан бичгээр Монголбанкны үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар, Сангийн яаманд 09 дүгээр сарын 03-ны өдөр "Мэдээлэл хүсэх тухай" 01/2048 дугаартай албан бичгээр Засгийн газрын үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар, 01/2053 дугаартай албан бичгээр төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах боломжтой эсэх талаар мэдээлэл авахаар тус тус хүсэлт гаргаад байна.
---	---	---	---	---	---	-----	---

		1	123,950,920.0	1	25,000,000.0	1	98,950,920.0	20.2	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу 2024 онд тэтгэврийн нөөц санд 336.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 212.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд: 1. 2024 онд тэтгэврийн даатгалын санд 3,940.1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 3,573.1 тэрбум төгрөг бүрдүүлж, сангийн орлогын төлөвлөгөө 367.0 тэрбум төгрөгөөр тасарч 90.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан. 2. Бүх төрлийн тэтгэврийг хугацаанд нь буюу тухайн сарын 01-ний өдөр олгодог. 2024 оны эхний 1-7 сар бүр дунджаар шимтгэлийн орлогоор 300.0 тэрбум төгрөг бүрдүүлж, улсын төсвийн санхүүжилтээр сард дунджаар 143.6 тэрбум төгрөг авч байсан тул 404.0 орчим тэрбум төгрөгийг тэтгэвэрт зарцуулж, 30.0 орчим тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд хуримтлуулсан. Харин 8 дугаар сараас эхлэн төсвийн хуваарийн дагуу улсын төсвөөс 32.0 тэрбум төгрөг авч байсан, сангийн орлогыг тэтгэврийн санхүүжилтийн дутагдаж буй эх үүсвэрт зарцуулах шаардлагатай тул 08 дугаар сараас хойш тэтгэврийн нөөц санд хөрөнгө байршуулах боломжгүй байсантай холбоотой. 3. 2024 онд үүссэн дээрх нөхцөл байдлын талаар тус газар 2 удаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүсэлт тавьсан. 2025 онд тэтгэврийн нөөц санд 25.0 тэрбум төгрөг нэмж байршуулсан.
		3	138,082,341.5	3.0	39,131,421.5	0	-	73.4	
17 НДЭГ төв сан	Шилэн дансны цахим хуудсанд 167 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1		1		0	-	100	Шилэн дансны цахим хуудсанд 167 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байсныг нөхөн оруулсан бөгөөд 2025 оны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна.
	Дүн	1	-	1	-	0	-	100	
	НИЙТ ДҮН	35	170,114,391.0	26	64,675,161.2	9	6,488,309.8	87.7	

Танилцсан: Дотоод аудит, мониторингийн газрын дарга
/Албан тушаал/

Нэгтгэсэн: Дотоод аудит, мониторингийн газрын мэргэжилтэн
/Албан тушаал/

/Д.Оюунтуяа/

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН
ТӨЛБӨР, ЗӨРЧЛИЙН БИЕЛЭЛТ
/2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар/

/Албан шаардлага/

/мян.төг/

А.А	Байгууллага	Алдаа зөрчлийн товч ууга болон Зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, залл	Аудитаар өгөгдсөн албан шаардлага		Биелэлт		Үлдэгдэл		Биелэлт Хувь	Биелээгүй шалтгаан, тайлбар
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Архангай аймгийн НДГ	Авлагатай холбоотой Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8/	1	5617.3		1850.3	1	3767.0	32.9	Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагын дагуу авлага барагдуулахаар шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байна. Аудитын албан шаардлагад дурдсан хугацаа болох 2025.12.01-ний өдрийн дотор авлагыг барагдуулахаар ажиллаж байна.
		Тайлангийн хуулийн хугацааг мөрдөж ажиллаагүй Төсвийн тухай хуулийн 8.9.2, 15.4.1, 16.5.7/	1		1		0	0	100	2025 оны 1-5 дугаар сарын Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайлангаа Sicos системээрээ мэдээлж тайлагнаж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.
2	Дорнод аймгийн НДГ	Санхүүгийн тайланг хугацаа хоцроон ирүүлсэн.	2	5617.3	1	1850.3	1	3767	66.5	Сангийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд тогтмол хүргүүлэн ажиллаж байна.
3	Өвөрхангай аймгийн НДГ	Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд НДСангийн санхүүгийн тайлан, мэдээ тайлан, баримт бичгийг ирүүлээгүй, тэтгэврийн даатгалын сан 179,180.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Төрийн аудитын тухай хуулийн 16.1.4, Төсвийн тухай хуулийн 8.9, мөн 8.9.2/	1	179180.5	1	179180.5	0	0	100	Нийгмийн даатгалын байгууллагын сангийн нягтлан бодох бүртгэлийн "Core" системийг нэвтрүүлж, программаар бүртгэж дуусаагүй байсан тэтгэврийн сангийн анхан шатны бүртгэл 179180.5 мян.төгрөгийг программд бүрэн бүртгэж 2025 оны 03 дугаар сарын 28-нд сангийн санхүүгийн тайланг шинэ программаар гаргах, Сангийн яамны Е-Баланс программд тайланг бүрэн шивх оруулсан. Санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж биелэлтийг Аймгийн аудитын газар хүргүүлсэн.
			1	179180.5	1	179180.5	0	0	100	

4	Сэлэнгэ аймгийн НДГ	Хувь хүний тэтгэвэр тэтгэмжийн тооцооллоос шалтгаалан авлага тайлант жилд үүсгэсэн. /Төсвийн тухай хуулийн 6.4.8, НББ тухай хуулийн 20.2.5/	1	94794.5	65656.9	1	29137.6	69.3	Тайлант онд нийт 114 тэтгэвэр аватгаад 72,742.4 мянган төгрөгийн тэтгэвэр илүү олгосон ба 2025 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар 76 иргэний 57752.2 мянган төгрөгийг барагдуулсан байна. Мөн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж нийт 22 иргэнд 22,052.1 мянган төгрөг илүү олгосон бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22 иргэний 7904.7 мянган төгрөгийг барагдуулж ажилласан.
		Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр тэтгэвэр, тэтгэмж олгосон /НББ тухай хуулийн 13.1, 13.7/	1	110443.9	110443.9	0	0	100	2024 оноос шинэ программд шилжсэн бөгөөд ажилгүйдлийн тэтгэмжийг иргэд даатгуулагчид portal.ndaatal.mn хаягаар хандан анхан шатны баримт бичгийг цахимаар бүрдүүлж хэвшсэн. НДЭГазрын даргын 2022.02.24-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар баталсан "Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ын 2.1.9 заалтын дагуу тэтгэвэр тогтоох материалыг бүрдүүлэн ажиллаж байна.
5	Төв аймгийн НДГ	Тайлант онд 603,072.1 мянган төгрөгийн авлага, 311,483.3 мянган төгрөгийн өглөг, нийт 914,555.3 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж, тулган баталгаажуулж байна. /НББ тухай хуулийн 20.2.5/	2	205238.4	176100.8	1	29137.6	84.6	Улсын төсвөөс авах татаас, санхүүжилтийн 1,225,139.6 мянган төгрөгийн авлага нь 2020 онд улс орон даяар үүссэн цар тахал Ковидын улмаас улсын төсвийн санхүүжилтээс үлдсэн авлагын тооцоо бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газрын сан хариуцсан мэргэжилтэнтэй тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдэж баталгаажуулсан.
		НДЭГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/240 дүгээр тушаалаар батлагдсан орлогын төлөвлөгөөнд хуримтлагдсан авлагаас 1,764,181.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 1,215,194.3 мянган төгрөгийг барагдуулж 549,987.5 мянган төгрөгийн авлагыг дууту төвлөрүүлсэн байна. /Төсвийн тухай хуулийн 16.1, 16.5.2/	1	548987.5	548987.5	0	0	100	Нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өртэй, насжилт өндөртэй, найдваргүй болох эрсдэлтэй, анхаарал татаж буй аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэлийн өрийн судалгааг гаргаж, уулзалт зохион байгуулан, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөхгүй байгаа нөхцөл байдал, шалтгааныг тодруулах, нийгмийн даатгалын ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагчдад сурталчлан таниулах, шаардлагатай мэдээллийг өгч ажиллаж байна. Мөн Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулах талаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллах, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах ажлыг зохион байгуулж өмнөх онд өртэй байгууллагын өрийн барагдуулж ажиллалаа. Өмнөх онд өртэй гарсан Баянөнжүүл сумын хүн эмнэлэгийн илүү тайлагнасан цалинд залруулга хийхээр аймгийн Санхүү хяналт дотоод аудитын газраас ирүүлсэн актыг мэдээллийн санд залруулга хийж авлагыг 100 хувь барагдуулсан.

	Батлагдсан орлогын төлөвлөгөөний биелэлт 99.4 хувьтай буюу 122,363.9 мянган төгрөгөөр тасарсан байна. /Төсвийн тухай хуулийн 6.1, 16.5.1, 16.5.2/	1	122363.9	1	122363.9	0	0	100	2025 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэхээр ажиллаж байна. Төлөвлөгөөг хагас жилийн байдлаар 100.5 хувиар давуулан биелүүлэв.
6	Хэнтий аймгийн НДГ	3	1585906.7	3	1585906.7	0	0	100	17 байгууллагын 131930.1 мянган төгрөгийн шимтгэлийн авлага дээр албан шаардлага өгсөн, 5 байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бүрэн барагдсан. 9 ААН-ын 96942.0 мянган төгрөгийн авлагад Шүүхийн шийдвэр гаргуулж ШШГГазартай хамтран ажиллаж байна. 1 байгууллагын 1188.0 мянган төгрөгийн дансыг хаасан. Татан буулгасан 1 байгууллагын 6976.4 мянган төгрөгийн авлага байгаа ба эдгээр авлагыг 2025 онд багтаан бүрэн барагдуулахаар ажиллаж байна.
7	НДҮЗ	1	131930.1	0	22784.4	1	109145.7	17.3	Цэр тахал /Covid-19/-ыг даван туулах, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг баталж хэрэгжилтийг зохион байгуулсан. Уг хуулийн 4 дүгээр зүйлд "2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно" гэж заасны дагуу Засгийн газрын 2020 оны "Журам батлах тухай" 140 дүгээр тогтоолоор "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг баталсан. Уг журмын хүрээнд үүссэн авлага, өглөгийг шийдвэрлүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад НДЕГазрын даргын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/1304 дугаар албан бичиг, мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад НДЕГазрын даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/1942 дугаар албан бичгээр 2026-2028 оны төсвийн төсөл, төсөөллийн саналд оруулан ажиллаа.

	Капитал банкны эрх хүлээн авагчаас авлагад тооцуулан хүлээн авсан хөрөнгийг мөнгөн хөрөнгө болгох ажлыг эрчимжүүлэх /Төсвийн тухай хуулийн 5.1, 6.4, 6.4.8./	1	13532984.8				1	13532984.8	-	Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахаар үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 байгууллагатай хамтран ажиллаж байна. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагаар дамжуулан 3,628.58 сая төгрөгийн үнэлгээ бүхий үйлдвэр, үйлчилгээний зориулалттай 3 ширхэг хөрөнгийг худалдан борлуулахаар сонирхогч талуудтай уулзалт зохион байгуулан, санал солилцож, саналын дагуу дээрх хөрөнгүүдийн талбайн хэмжилт, цахилгаан, дулаан, цэвэр бохир усаар хангах гэрээг байгуулах, техникийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.
8	НДСҮЗ дарга	2	720148984.8	0	0	2	720148984.8	10.8	-	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181/ШШ2020/02624 дугаар шүүгчийн захирамжаар Чингис хаан банк ХХК-иас 101.7 тэрбум төгрөгийг гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн. Иймд тус газар нь 2021 онд хүүгийн орлого 2.3 тэрбум төгрөгийн нэхэмжлэл гаргаснаар тус шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 181/ШШ2024/00464 шүүгчийн захирамжаар Чингис хаан банк ХХК-иас 1.8 тэрбум төгрөгийг гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн. Энэ дүнг нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлд Чингис хаан банкнаас авах хүүгийн авлагаар бүртгэсэн. 2025 онд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 08 дугаар тогтоол, 2025 оны 13 дугаар тогтоолын дагуу Чингис хаан банкнаас нийт 7.49 тэрбум төгрөгийн үнэ бүхий 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан. Мөнгөн хөрөнгөөр 2.76 тэрбум төгрөг, нийт 10.25 тэрбум төгрөгийг барагдуулж авлагын үлдэгдэл 84.95 тэрбум төгрөг байна.
	Чингис хаан банкинд байршиж буй НДСангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 93.4 тэрбум төгрөг Чингис хаан банкныг татан буулгах шийдвэр гаргагүй тул санхүү, бүртгэлд авлагаар бүртгэх эрх зүй бүрдээгүй, НДСангийн хөрөнгө эрсдэлтэй байна. Үлдэгдэлд тооцсон хүү 1.8 тэрбум төгрөгийг төлбөр барагдуулах дараалал хүлээгдэж байгаагаас шалтгаалан барагдаагүй үлдэгдэлтэй байна /Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.8, 14.2.3, НББ тухай хуулийн 20.2.5/	1	95201086.7		10253925.1	1	84947161.6			

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагыг барагдуулах ажил удаашралтай /Төсвийн тухай хуулийн 6.4, 6.4.8, НББ тухай хуулийн 20.2.5, 20.2.6/	1	65701545.3		1513362.5	1	64188182.8	2.3	Нийгмийн даатгалын ерөнхий газраас Капитал Банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг Капитал банканд дахь банкны эрх хүлээн авагчтай тооцоо нийлж, 104.2 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулахаар Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж, 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн шүүгчийн 182/ШШ2020/02419 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан. 2025 онд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 1.21 тэрбум төгрөгийн үнэ бүхий 9 ширхэг үл хөдлөх хөрөнгийг өр төлбөрт тооцон шилжүүлэн авсан. Мөнгөн хөрөнгөөр 300.0 сая төгрөг, нийтдээ 40.02 тэрбум төгрөгийн авлага барагдуулж, 64.18 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. -Капитал банкны өр төлбөрийн үлдэгдлийг банкны өөрийн болон эзлийн барьцаанд байгаа нүүгдмал хөрөнгийг олж илрүүлэн нийгмийн даатгалын санд учирсан хохирлыг арилгах, өр төлбөрийг бүрэн барагдуулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаар Авлигатай тэмцэх газрын төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулсан. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 75 дугаар захирамжаар төлбөрийн чадваргүйн улмаас санхүүгийн эрсдэлд орсон, татан буугдсан банканд байршиж байсан тусгай зориулалтын сан, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ТӨБЗГ, ШШГЕГ, Монголбанк, Сангийн яам, Боловсролын яам, НДЕГ, ЭМДЕГ, ХХҮЕГ, АТГ Хөгжлийн банк, Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч зэрэг байгууллагын төлөөллүүдийг оролцуулан байгуулсан. -Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүсэлтүүдийг удаа дараа хүргүүлсэн боловч хамтран эзэмшиж буй хөрөнгийг худалдан борлуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй, худалдан борлуулах ажиллагаанд тухайн байгууллага манай байгууллагаас зөрүүтэй саналыг өгдөг бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрээр Чингис хаан банкны авлагыг барагдуулах, Банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулахаар ажиллаж байна.
---	---	------------	--	-----------	---	------------	-----	---

Тайлант онд олон жилийн насжилттай, найдваргүй эрсдэлтэй иргэн/аж ахуй нэгж байгууллагаас авах өмнөх оны авлагын үлдэгдлийг бууруулаагүй, хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч барагдуулалт хийгдээгүй /Гэсгийн тухай хуулийн 6.4, 6.4.8, НББ тухай хуулийн 20.2.5, 20.2.6/	1	6444784.3	1	6444784.3	Хуримтлагдсан авлагыг барагдуулахаар шүүхийн байгууллагад нэхэмжлэл гарган ажиллах байна. Үүнд: 1. НИХДЭШШҮҮГЧИЙН 2025.01.31-ний өдрийн "НДЕГ-ын нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай" 210/МАА2025/00237 дугаартай магадлалаар "Дорнын говь" ХХК-иас 150.0 сая төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн боловч ДШХШХШҮХ хуралдааны 2025.04.22-ны өдрийн 001/ХТ2025/00087 дугаар тогтоолоор дээрх шийдвэрийг хүчингүй болгосон. 2. СХДИХАШШҮҮГЧИЙН 2024.12.16-ны өдрийн 01/2592 дугаартай албан бичгээр даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох санхүүжилтийн мөнгийг НДС-д төлүүлэх, НДС-н авлагыг барагдуулах шаардлагатай байх тул "Өндөр гэгээн" ХХК-иас 111,765,000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ИХАШТШҮҮГЧИЙН 2025.01.21-ний өдрийн "Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" 192/ШЗ2025/04248 дугаар захирамжаар хариуцагчийн хагт тодорхойгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧД 2025.02.10-ны өдөр "Нэхэмжлэл гаргах тухай" 01/289 дугаар албан бичгээр "Өндөргэгээн" ХХК-ийг эрэн сурвалжуулахаар нэхэмжлэл гаргасан. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧИЙН 2025.03.27-ны өдрийн 191/ШЗ2025/02588 дугаар шийдвэрээр "Өндөр гэгээн" ХХК-ийг эрэн сурвалжулахаар шийдвэрлэсэн. 3. Баянгол дүүргийн ИХАШТШҮҮГЧД "Их тэргүүн" ХХК-иас 1,050,000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. Дүүргийн ЭИХХААШТШҮҮГЧИЙН 2025.05.15-ны өдрийн 197/ШЗ2025/24178 дугаар захирамжаар хариуцагчийн оршин байгаа хагт тодорхойгүй гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧД 2025.08.26-ны өдөр 01/1969 дугаар албан бичгээр "Их тэргүүн" ХХК-ийг болон түүнийг төлөөлөх этгээдийг эрэн сурвалжуулах нэхэмжлэл гаргасан. 4. Сүхбаатар дүүргийн ИХАШТШҮҮГЧД "Их өргөө" ХХК-иас 1,500,000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. ДЭИХХААШТШҮҮГЧИЙН 2025.06.05-ны өдрийн 197/ШЗ2025/07474 дугаар шийдвэрээр хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 5. Баянзүрх дүүргийн ИХАШТШҮҮГЧД Зэвсэгт хүчний жанжин штабаас 5,893,785 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧИЙН 2025.05.14-ний өдрийн 191/ШЗ2025/1454 дугаар захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Дүүргийн ЭИХХААШТШҮҮГЧД 2025.08.27-ны өдөр 01/1983 дугаар албан бичгээр Зэвсэгт хүчний жанжин штабаас 5,893,785 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. 6. Баянгол дүүргийн ИХАШТШҮҮГЧД Монтех ХХК-с 4,400,000 төгрөг нэхэмжилсэн ба Дүүргийн ЭИХХААШТШҮҮГЧИЙН 2025.07.18-ны өдрийн 197/ШЗ2025/40315 дугаар захирамжаар хэргийг хэрэгсэхгүй болгосон. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧД Монтех ХХК болон түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийг эрэн сурвалжуулах нэхэмжлэл гаргасан. 7. Баянгол дүүргийн ИХАШТШҮҮГЧД 2024.12.16-ны өдрийн 01/2591 дугаартай албан бичгээр иргэн Пүрэдаваагаас 50,000,000 төгрөгийг гаргуулж өгнө үү гэсэн нэхэмжлэх гаргасан. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн ИХАШТШҮҮГЧИЙН 2025.02.10-ны өдрийн "Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" 192/ШЗ2025/007793 дугаартай захирамжаар нэхэмжлэлд дурьдсан хаягт бүртгэлтэй боловч оршин суудаггүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон. Тус газраас Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧД 01/477 дугаартай албан бичгээр нэхэмжлэл гаргасан. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ИХАШТШҮҮГЧИЙН 2025.04.14-ний өдрийн 191/ШЗ2025/03108 дугаар шийдвэрээр нас барсан тул хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 8. Монголбанкны ерөнхийлөгчийн шийдвэрээр дамлуурсан татан буугдсан банкуудаас авах 5.4 тэрбум төгрөгийн авлагыг татан буугдсан шийдвэр болон ирүүлсэн албан бичгийг үндэслэн хааж болох эсэх талаар зөвлөмж өгөхийг хүсч Сангийн яаманд 2025.09.02-ны өдөр 01/2029 дугаартай "Чиглэл хүсэх тухай" албан бичиг хүргүүлсэн. 9. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний компанийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулан хамтран ажиллах талаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2025.09.19-ний өдөр "Төлбөр барагдуулах тухай" 01/2305 дугаартай албан бичиг хүргүүлэн ажиллалаа.
--	---	-----------	---	-----------	--

[illegible]


ан	1. Өмнөх оны аудитаар өрсөн Капитал банкны эрх хүлээн авагчаас авлагад тооцож авсан СБД-ын Сэлбэ амралтын газрын 3,240 м2 газрын түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын тогтоосон түрээсийн төлбөрөөс доогуур үнээр тогтоосон, гэрээг шинэчлэхгүй зөрчилгүй арилгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллагаагүй байна.	170189.5	1	170189.5	-	1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /56.71 хувь/ болон Нийтийн даатгалын ерөнхий газрын /43.29 хувь/ хамтран эзэмшдэг Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Сэлбэ /14020/ 18 дугаар хэсэг гудамж, 1801 тоот хаягт байрлах 3240 м.кв үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр "Эрхэт Монгол" ХХК ТТ-10/22 дугаар "Түрээсийн гэрээ" байгуулан түрээслүүлсэн. Дээрх хөрөнгийг НДЕГ нь дангаар эзэмшдэггүй ба ЭМДЕГ нь хөрөнгийн 50-иас дээш хувийг эзэмшдэг болно. Манай байгууллагын зүгээс 2024 онд түрээслэгч Эрхэт Монгол ХХК-д удаа дараа албан бичиг хүргүүлж /хувийг ЭМДЕГ-т/ уулзалт зохион байгуулах, түрээсийн гэрээг өөрчлөх, дуусгавар болгох талаар арга хэмжээ авсан боловч тухайн байгууллага нь удаа дараа зайлсхийж, хамтран ажиллах боломжгүй байна. Банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. 2. БЗД, 16-р хороо, 16 хороолол /13320/ Д.Нянтайсүрэngийн гудамж, 75 байранд байршилтай худалдаа, үйлчилгээний зориулалттай хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай /56.71 хувь/ хамтран эзэмшдэг. Дээрх хөрөнгийн 196 м.кв талбайг ТӨБЗГ-ын 2020 оны 49-р тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн доод үнэлгээгээр 2021 оноос хойш Очирт Оргил Оюу ХХК-тай гутлын үйлдвэрлэлийн зориулалтаар м.кв 10,200 төгрөгөөр, 2021 оны 11 сараас 2024 оны 8 сарыг дуустал 226 м.кв талбайг интернет тоглоомын газрын зориулалтаар Б.Батсайханд м.кв 6,000 төгрөгөөр, 2024 оны 10 сараас эхлэн 226 м.кв талбайг билъярд клубын зориулалтаар Э.Мөнхсэрд м.кв 10,000 төгрөгөөр түрээслүүлсэн. Дээрх хөрөнгийг худалдан борлуулахаар сонирхогч талтай уулзалт зохион байгуулан ажиллаж байна. Урьдчилгаа төлбөр төлөгдсөн тохиолдолд түрээслэгч нэртэй байгуулсан гэрээг цуцалж, талбайг чөлөөлөх мэдэгдэл хүргүүлнэ. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүсэлтүүдийг удаа дараа хүргүүлсэн. Тухайн газраас хамтран эзэмшиж буй хөрөнгийг худалдан борлуулах талаар тодорхой арга хэмжээ авахгүй, худалдан борлуулах ажиллагаанд тухайн байгууллага манай байгууллагаас зөрүүтэй саналтай байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны шийдвэрээр Чингис хаан Банкны авлагыг барагдуулах, Банкны эрх хүлээн авагчаас шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.
----	---	----------	---	----------	---	---

1. 3Г болон Азийн хөгжлийн Банкны хооронд байгуулсан зээлийн гэрээний санхүүжилтээр ХНХЯ /хуучин нэрээр/, НДЕГ нь "Ай Ти Зон" ХХК-тай "НД" ын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх" ажлын гэрээг 2019.07.30-ны өдөр 2 жилийн хугацаанд гүйцэтгэхээр байгуулсан боловч бүрэн дуусаагүй системийг 2024.01.01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн байна.	1	1	0	0	0	100	Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын хүрээнд системд нэмэлт, хөгжүүлэлтүүдийг хийснээр иргэд, даатгуулагчид цахимаар үзүүлж байгаа үйлчилгээ хэвийн Үүнд: 1. Тайлант онд цахимаар 470.6 мянган иргэн, даатгуулагчаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолох болон сайн дураар даатгуулах хүсэлт, сар бүр 60.0 орчим мянган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна. Тухайлбал: - Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, шимтгэл төлөх 149.0 мянган цахим хүсэлт; - Өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээлчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолох 89.0 мянган иргэний цахим хүсэлтийг тус тус шийдвэрлэжээ. -Нийт 520.0 орчим мянга тэтгэвэр авагч /давхардсан тоогоор нийтдээ 6.5 сая/-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг сар бүр системээр тооцоолж, харилцагч арилжааны банкууд руу цахимаар илгээснээр сар бүрийн 01-ний өдөр тэтгэвэр авагчдын дансанд тэтгэврийг шилжүүлсэн. - Нийт 60.0 орчим мянган ажил олгогчийн сар бүр илгээсэн 566.7 мянган удаагийн, давхардсан тоогоор 8.6 сая албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 100 % цахимаар хүлээн авч шийдвэрлэлээ. - Ажил олгогчоос цахимаар илгээсэн 127.5 мянган албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч, тэтгэмжийн тооцооллыг хийж цахим үйлчилгээ үзүүлэв. 2. Мэдээллийн нэгдсэн систем нь төрийн цахим мэдээлэл солилцооны "Хур" системээс аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн мэдээллийг татах, түүнчлэн өмнөх системийн өгөгдлийн санг шинэ системд хөрвүүлэхэд ажил олгогчоос буруу илгээсэн регистрийн зөрүүг арилгах зэрэг систем хоорондын шилжилт хийгдсэнтэй холбоотой нэвтрүүлэх явцад иргэд, даатгуулагчид олгох тэтгэмжийн хүсэлт эхний 3 сард хугацаа алдаж шийдвэрлэгдэж байсан бөгөөд системд нэмэлт хөгжүүлэлт хийснээр одоогийн байдлаар хэвийн болсон. - Мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу албан журмаар даатгуулагчтай холбоотой зөрчлийг бүртгэх, акт, алданги, торгууль ногдуулах үйл ажиллагааг системээр тооцоолох, түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэл хийх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд 2024 онд нийтдээ 1402 ажил олгогчоос 7448 даатгуулагчийн давхардсан тоогоор 52536 хүн/сар цалин засварын мэдээллийг нөхөн авч системд оруулсан байна. 3. Системийн хөгжүүлэлт, сайжруулалт, түүнийг систем хэрэглэгчид бүрэн ойлгоогүйгээс систем ашиглах, мэдээлэл боловсруулах, мэдээллийг гаргах зэрэг үйлдлүүдийг дутуу ашиглах асуудлууд гарч байгаатай холбогдуулан гадагшаа болон дотошоо чиглэсэн сургалтуудыг янз бүрийн байдлаар зохион байгуулан ажиллаж байна. Сургалтын хүрээнд нийгмийн даатгалын салбарын систем хэрэглэгч 1500 орчим ажилтнуудыг зайнаас сургахаас гадна сургагч багш бэлтгэх ажлыг эхлүүлээд байна. 4. Нийгмийн даатгалын мэдээллийн санг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар ажиллуулахад систем ачаалах, удаашрах зэргээс шалтгаалан гацах, мэдээллийг дутуу татах тохиолдлууд гарч байгаа ба энэ хүрээнд системийг ачаалах чадвартай, хүчин чадал өндөр, хурдтай, сүүлийн үеийн сервер шаардлагатай байгаа тул хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
2. Бүрэн дуусаагүй системийг хэрэглэнд, нэвтрүүлсэн нь иргэн, ААНБ-дад дараах хүндрэлүүд үүссэн байна. Тухайлбал:							
- ХЧТА тэтгэмж, болон амаржсаны тэтгэмжийг хугацаа алдаж шийдвэрлэгдэж байна.							
- НЦШ-ийг нөхөн төлүүлэхэд НД-7, 8 тайланг хүлээж авахгүй, 3."SICOS" систем нь авлага, өглөгийн дэлгэрэнгүй тайлан бэлтгэгдэггүй, мөнгөн гүйлгээний болон ерөнхий журналыг дэлгэрэнгүй байдлаар excel файл руу хөрвүүлэхэд их ачаалалаг, данс, дансаараа тус тусдаа татагддаг							
/Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 17.1, 17.2, НББ тухай хуулийн 8.2, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.5, 14.4.6, 20.2.3, Төсвийн тухай хуулийн 5.1.3/							

	Өмнөх оны аудитаар өгсөн 2006 оноос хуримтлагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 39.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. /НББ тухай 5.1.4, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10/	1	39491.8		1	39491.8	-	Элэн жилийн насжилттай хуримтлагдсан өглөгийн эзэн холбогдогч тодорхойгүй тул тооцоо нийлж, авлага барагдуулах боломжгүй байна.
	Дүн	3	209681.3	1	0	2	209681.3	33.3
	НИЙТ ДҮН	20	889821248.4	10	13740403.3	10	876080845.10	56.6

Танилцсан: Дотоод аудит, мониторингийн газрын дарга
/Албан тушаал/

Нэгтгэсэн: Дотоод аудит, мониторингийн газрын мэргэжилтэн
/Албан тушаал/

 /Б.Ганхуяг/
 /Д.Оюунтуяа/